

ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРААС ХАРИУЦАН ШИЙДВЭРЛҮҮЛЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛҮҮДИЙН ТАЛААРХ

Нэг. Тусгай зөвшөөрлийн тухай

Монгол Улсын Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5.2.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 8.4, 8.5, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10.б-д тус тус заасны дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын тушаалаар дараах тусгай зөвшөөрлүүдийг олгох, сунгах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✓ Бүх төрлийн шатахуун, шатдаг хий импортлох;
- ✓ Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн бөөний худалдаа эрхлэх;
- ✓ Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн жижиглэнгийн худалдаа эрхлэх.

Эдгээр тусгай зөвшөөрлүүдийг 2022 оны 3 дугаар сараас эхлэн 100 хувь цахим системд шилжүүлсэн бөгөөд Сангийн яамны харъяа Гааль, татвар мэдээлэл, технологийн төвийн хариуцдаг www.license.mn тусгай зөвшөөрлийн цахим системээр дамжуулан тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн бүрдлийг аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч, холбогдох албан Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанд цахимаар материал тус бүрээр хянаж, анхан шатны шийдвэрлэлтийг гүйцэтгэдэг.

Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн чиглэлээр олгож буй тусгай зөвшөөрлүүд нь тус яамнаас олгож буй бусад зөвшөөрлүүдтэй харьцуулахад илүү олон тооны давтамжтай тогтмол орж ирдэг, түүнчлэн тусгай зөвшөөрлийн ихэнх хувийг эзэлж буй “жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл” нь ихэвчлэн хөдөө орон нутаг, алслагдсан аймаг, сумдаас ирүүлсэн хүсэлтүүд эзэлдэг.

Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн тусгай зөвшөөрлүүдээс зөвхөн “Бөөний худалдаа эрхлэх” төрөл нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу анх удаа авах болон сунгуулах бүрт тусгай зөвшөөрлийн төлбөр төлдөг. Үүнд:

- ✓ Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх 50 сая төгрөг;
- ✓ Шатдаг хийн түлшний бөөний худалдаа эрхлэх 1 сая төгрөг;
- ✓ Ахуйн хэрэглээний 220-500 гр шатдаг хийн бөөний худалдаа эрхлэх 100,000 төгрөг.

Хоёр. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах хуулийн заалтууд:

2.1 Зөвшөөрлийн тухай хууль:

8.Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

8.4.бүх төрлийн шатахууны бөөний, жижиглэнгийн худалдаа эрхлэх	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8.5.бүх төрлийн шатахууныг импортлох	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8.6.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8.7.газрын тос, уламжлалт бус газрын тос хайх, ашиглах	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

2.2 Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль:

- 4.1.6. “бүх төрлийн шатахууны бөөний худалдаа” гэж энэ хуулийн 4.1.7-д заасан бүтээгдэхүүнийг энэ хуулийн 4.1.3-т заасан агуулахаас борлуулахыг;
- 4.1.7. “бүх төрлийн шатахуун” гэж боловсруулах үйлдвэрт технологийн дагуу боловсруулагдсан эцсийн бүтээгдэхүүн буюу автобензин, дизель түлш, онгоцны түлш, шатдаг хий болон керосин, дайвар бүтээгдэхүүн;
- 4.1.8. “бүх төрлийн шатахууны жижиглэнгийн худалдаа” гэж энэ хуулийн 4.1.7-д заасан бүтээгдэхүүнийг түгээх станц, зориулалтын цэгээс борлуулахыг;
- 5.2.2. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бүх төрлийн шатахууны импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- 7.3. Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:
- 7.3.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;
- 7.3.2. нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, орчуулгын хамт;
- 7.3.3. бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, орчуулгын хамт.
- 7.4. Энэ хуулийн 7.3-т заасан тусгай зөвшөөрлийг бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд олгоно.
- 7.5. Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад энэ хуулийн 7.3-т зааснаас гадна Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 8-д заасны дагуу газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг хавсаргана.

Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх

- 8.1. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.
- 8.2. Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн технологи, тоног төхөөрөмж олон улсын стандартад нийцсэн байна.
- 8.3. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:
- 8.3.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;
- 8.3.2. үйлдвэрлэлийн төсөл буюу техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байх;
- 8.3.3. мэргэжлийн байгууллагын дүгнэлт;
- 8.3.4. түүхий эд нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, орчуулгын хамт.
- 8.4. Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь үүрэг хүлээнэ:
- 8.4.1. үндэсний стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- 8.4.2. газрын тосны бүтээгдэхүүний чанарын шинжилгээ, туршилт хийх итгэмжлэгдсэн лабораторитой байх;
- 8.4.3. үйлдвэрийн хаягдлыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хор нөлөө үзүүлэхээргүй орчинд хадгалах, зайлуулах, устгах нөхцөлийг бүрдүүлэх.
- 8.5. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад энэ хуулийн 8.3-т зааснаас гадна Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 8-д заасны дагуу газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг хавсаргана.

- 9.1. Бүх төрлийн шатахууны бөөний болон жижиглэнгийн худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.
- 9.2. Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:
- 9.2.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;
- 9.2.2. агуулахын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээ;

9.2.3.мэргэжлийн байгууллагын дүгнэлт

9.4.Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад энэ хуулийн 9.2-т зааснаас гадна Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 8-д заасны дагуу газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг хавсаргана.

9.5.Бүх төрлийн шатахууны жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

9.5.1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

9.5.2.жижиглэнгийн худалдаа эрхлэх үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээ;

9.5.3.мэргэжлийн байгууллагын дүгнэлт.

9.6.Бүх төрлийн шатахууны жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад энэ хуулийн 9.5-д зааснаас гадна Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 8-д заасны дагуу газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг хавсаргана.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль:

25.1.10.б.1.автобензин, дизель түлш, онгоцны түлшний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 50.000.000 төгрөг;

25.1.10.б.2.шатдаг хийн түлшний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 1.000.000 төгрөг;

25.1.10.б.3.жижиглэн савласан /220гр-500гр/ газрын тосны шингэрүүлсэн хийн бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100.000 төгрөг.

ГАЗРЫН ТОС, УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ОЛГОЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Газрын тосны тухай хуулийн 18 дугаар зүйл, 24 дүгээр зүйл, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 8.7, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10.в, 25.1.10.г-д тус тус заасны дагуу Газрын тос, уламжлалт бус газрын тос хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг тус яамнаас олгож байна.

ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ

18.2.Хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

18.2.1.бүтээгдэхүүн хуваах гэрээний хуулбар;

18.2.2.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

18.2.3.тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө;

18.2.4.энэ хуулийн 11.2.9-д заасан мөнгөн хөрөнгийг байршуулсан баримт.

18.3.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 18.1, 18.2-т заасан баримт бичгийг хянан үзэж, хайгуулын тусгай зөвшөөрлийг хайгуулын хугацаагаар дараах этгээдэд олгож, сунгана:

18.3.1.эрлийн ажлын үр дүнд бүтээгдэхүүн хуваах гэрээ шууд байгуулсан;

18.3.2.энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу гэрээ байгуулсан.

18.4.Газрын тосны хайгуулын хугацаа найм хүртэл жил байх бөгөөд уг хугацааг төрийн захиргааны байгууллага хоёр хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно.

18.5.Уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа арав хүртэл жил байх бөгөөд уг хугацааг төрийн захиргааны байгууллага тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.

18.6.Бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулсан өдрөөс хайгуулын хугацааг тооцно.

18.7.Хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн хугацааг хуанлийн жилээр тооцно.

18.8.Төрийн захиргааны байгууллага эхний жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан өдрөөс хойш 120 хоногийн дотор, дараагийн жилээс хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг тухайн жилийн эхний улиралд багтаан батална.

18.9.Төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 18.3-т заасан хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг хоёр хүртэл жилээр хоёр удаа сунгаж болох бөгөөд энэ тохиолдолд гэрээлэгч доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, төрийн захиргааны байгууллагаар дамжуулан төрийн захиргааны төв байгууллагад хугацаа сунгах хүсэлтээ ирүүлнэ:

18.9.1.хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлан;

18.9.2.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайлан;

18.9.3.сунгасан хугацаанд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл.

18.10.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 18.9-д заасан баримт бичгийг хянаж хугацааг сунгах үндэслэлтэй гэж үзвэл энэ хуульд заасан хугацаагаар сунгана.

18.11.Төрийн захиргааны байгууллага нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

18.12.Хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгэх үүргээ хоёр буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй тохиолдолд хайгуулын хугацааг сунгахгүй.

ГАЗРЫН ТОСНЫ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ

24.1.Газрын тосны нөөцийг хүлээн авах тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гэрээлэгч ашиглалтын үйл ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргана.

24.2.Гэрээлэгч ашиглалт эхлэхээс өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл авах бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс ашиглалтын хугацаа эхэлнэ.

24.3.Ашиглалтын тусгай зөвшөөрлийг холбогдох хуулийн дагуу төрийн захиргааны төв байгууллага гэрээлэгчид олгож, сунгана.

24.4.Гэрээлэгч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад дараах баримт бичгийг бүрдүүлж төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ:

24.4.1.газрын тосны нөөц бүртгэсэн тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр;

24.4.2.тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл;

24.4.3.орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө;

24.4.4.ашиглалтын үеийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ;

24.4.5.эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас баталсан нэг загварын байр зүйн зураг дээр ашиглалтын талбайн булангийн цэгүүдийн солбицлыг градус, секундээр тодорхойлж тэмдэглэсэн зураг;

24.4.6.энэ хуулийн 11.2.9-д заасан мөнгөн хөрөнгийг байршуулсан баримт.

24.5.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тохиолдолд гэрээлэгч дараах баримт бичгийг бүрдүүлэн төрийн захиргааны байгууллагаар дамжуулан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ:

24.5.1.ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлт, үндэслэл;

24.5.2.ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлан;

24.5.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайлан;

- 24.5.4. тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл.
- 24.6. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 90 хоногийн дотор энэ хуулийн 24.4.5-д заасны дагуу ашиглалтын талбайн хилийн хэмжилт хийж, шав тэмдэг тавих ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.
- 24.7. Төрийн захиргааны төв байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.
- 24.8. Энэ хуулийн 18.13-т заасан хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид төрийн захиргааны төв байгууллага нь ашиглалт эхлэхээс өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоно.